



## ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 1126

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41,42,43 дугаар тушаал, Нийслэлийн засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/357 тоот захирамж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”, халдвар тархалтын “Улбар шар түвшин”-д шилжүүлсэн хугацаанд ажлын байранд ирж ажиллах ажилтан, албан хаагчдын нэрсийг (нийт ажилтан, албан хаагчдын 30 хувь) хавсралтаар баталж, бусад ажилтнуудыг ажлын байранд ирүүлэхгүй цахимаар ажилуулсугай.

2. Байгууллагын дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааг идэвхижүүлж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн, байгууллагаас зохион байгуулж, вакцинд хамруулсан арга хэмжээнээс хоцорсон вакцинд хамрагдаагүй ажилтан, албан хаагчдаа Коронавируст (Ковид-19) халдварын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамруулж, дархлаажуулалтад хамрагдсан болон өвчилж эдгэрсэн хүний эмнэлгийн магадлагааг үндэслэн ажиллуулахыг хэлтсийн дарга нарт (Л.Эрдэнэбат, Л.Ганбат, Э.Энхбаяр, Ш.Энхжаргал, Э.Уянга, Г.Уранбайгал, В.Мөнхжаргал, Б.Гүнжидмаа) зөвлөсүгэй.

3. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил болон хугацаа шахагдаж байгаа гэрээт ажлуудыг хүний нөөц болон техникийн нөөцийг бүрэн ашиглаж график төлөвлөгөө гарган, зөв зохион байгуулж ажиллахыг хэлтсийн дарга нар (Л.Ганбат, В.Мөнхжаргал, Э.Энхбаяр, Ш.Энхжаргал, Г.Уранбайгал, Б.Гүнжидмаа, Э.Уянга) болон ажлын хэсгийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Цаг үеийн нөхцөл байдалд тохируулан дээрх ажлуудыг чанартай гүйцэтгүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Судалгаа хариуцсан орлогч дарга (С.Очир-Эрдэнэ), Ерөнхий инженер (Ж.Баясгалан) нарт, ажилтнуудын ирц, ажлын цаг ашиглалт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА

ТУЗ1925 9020010718 5369568